**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/72/СТА-ТШ3***

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2021 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Дэлгэрмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: delgermaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9

3. Аудитын тайлан ..... 10

3.1. Ерөнхий зүйл ..... 10

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 10

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ..... 10

3.4. Материаллаг байдал ..... 11

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 11

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ..... 11

3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 12

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 12

3.9. Аудитын илрүүлэлт ..... 13

Залруулсан алдаа ..... 13

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..... 13

Аудитын зөвлөмж ..... 14

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 14

4. Менежментийн захидал ..... 14

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 15

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 123

танай ______ -ны № ______ -т

ХЭРЛЭН СУМЫН 3 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ҮДНАРАН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021246

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **49,745,088.50** | **41,698,374.98** |
| **33** | **АВЛАГА** | 49,745,088.50 | 656,915.00 |
| 33402 | Татвар | | 656,915.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 49,745,088.50 | 41,041,459.98 |
| **354** | **Хангамжийн материал** | 49,745,088.50 | 41,041,459.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,673,260.00 | 1,673,260.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 1,751,074.48 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 48,071,828.50 | 37,617,125.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,142,910,843.03** | **1,146,853,931.27** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,142,910,843.03 | 1,146,853,931.27 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,082,910,843.03 | 1,086,441,331.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,071,728,813.00 | 1,071,728,813.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -23,225,136.24 | -46,450,272.48 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21484650.00 | 28683072.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -11,795,936.00 | -14,819,716.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 38,853,732.88 | 42,700,830.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -36,306,028.64 | -36,842,185.04 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 40,966,600.00 | 68,402,700.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -18,795,851.97 | -26,961,910.29 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 60000000.00 | 60412600.00 |
| 39301 | Програм хангамж | 590,000.00 | 1,002,600.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -590,000.00 | -590,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 60,000,000.00 | 60,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,192,655,931.53** | **1,188,552,306.25** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,946,779,649.56** | **656,915.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 7,946,779,649.56 | 656,915.00 |
| **413** | **Өглөг** | 7,946,779,649.56 | 656,915.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 4,003,389,824.78 | 656,915.00 |
| 41363 | Хувь хүмүүст өгөх өглөг | | 656,915.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,192,655,931.53** | **1,187,895,391.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,192,655,931.53** | **1,187,895,391.25** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 779,038,980.86 | 779,038,980.86 |
| 51101 | Өмч: - төрийн | 779,038,980.86 | 779,038,980.86 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -64,084,084.69 | -68,844,624.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -64,084,084.69 | -64,084,084.69 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -4,760,540.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 477,701,035.36 | 477,701,035.36 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,192,655,931.53** | **1,188,552,306.25** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **368,309,816.00** | **468,046,120.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,755,816.00** | **40,131,620.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 695,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 695,000.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 695,000.00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 11,755,816.00 | 39,436,620.00 |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 11,755,816.00 | 39,436,620.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **24,597,000.00** | **19,824,200.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 331,957,000.00 | 408,090,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 297,000.00 | 140,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 297,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 19,684,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 19,684,200.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 24,300,000.00 | 00.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 24,300,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **388,412,861.16** | **472,806,660.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **388,412,861.16** | **472,806,660.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 384,077,360.57 | 458,712,637.78 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 244,592,525.11 | 318,197,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,046,182.11 | 262,253,110.60 |
| 210102 | Нэмэгдэл | 7,619,557.00 | 28,498,281.40 |
| 210104 | Урамшуулал | 18,926,786.00 | 27,446,308.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,596,100.00 | 42,751,639.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,805,700.00 | 29,845,639.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,447,400.00 | 3,199,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,958,100.00 | 2,559,840.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 489,400.00 | 639,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,895,500.00 | 6,506,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,183,307.30 | 17,830,165.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,541,882.00 | 3,050,192.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,636,671.00 | 9,670,744.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,004,754.30 | 5,109,229.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,559,989.00 | 15,803,873.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,570,339.00 | 527,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 396,000.00 | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,450.00 | 150,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 449,200.00 | 1,739,253.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 12,570,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,428,367.00 | 24,229,828.52 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 707,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,128,367.00 | 23,522,758.52 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,300,000.00 | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,300,000.00 | 1,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 99,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 99,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 625,500.00 | 544,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 445,500.00 | 304,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,791,572.16 | 37,455,531.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,060,000.00 | 604,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,481,572.16 | 36,601,131.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,335,500.59 | 14,094,022.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 374,236.00 | 150,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 174,236.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 150,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,961,264.59 | 13,944,022.50 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,961,264.59 | 13,944,022.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-20,103,045.16** | **-4,760,540.28** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **356,554,000.00** | **427,914,500.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **356,554,000.00** | **427,914,500.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 331,957,000.00 | 408,090,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 297,000.00 | 140,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 297,000.00 | 140,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 24,300,000.00 | 19,684,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 19,684,200.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 24,300,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **356,554,000.00** | **427,914,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **356,554,000.00** | **427,914,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **352,218,499.41** | **413,820,477.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 244,592,525.11 | 318,197,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,046,182.11 | 262,253,110.60 |
| 210102 | Нэмэгдэл | 7,619,557.00 | 28,498,281.40 |
| 210104 | Урамшуулал | 18,926,786.00 | 27,446,308.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,596,100.00 | 42,751,639.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,805,700.00 | 29,845,639.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,447,400.00 | 3,199,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,958,100.00 | 2,559,840.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 489,400.00 | 639,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,895,500.00 | 6,506,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,183,307.30 | 17,830,165.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,541,882.00 | 3,050,192.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,636,671.00 | 9,670,744.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,004,754.30 | 5,109,229.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,182,700.00 | 3,356,170.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,622,250.00 | 527,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 396,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 00.00 | 225,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 80,100.00 | 200,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,450.00 | 150,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,939,900.00 | 1,752,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,428,367.00 | 27,473,903.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 100,000.00 | 795,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 50,128,367.00 | 25,273,833.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 200,000.00 | 1,405,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,300,000.00 | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,300,000.00 | 1,800,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 99,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 625,500.00 | 957,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 445,500.00 | 717,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,310,000.00 | 1,354,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,060,000.00 | 1,104,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,335,500.59** | **14,094,022.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 374,236.00 | 150,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 174,236.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 150,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,961,264.59 | 13,944,022.50 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,961,264.59 | 13,944,022.50 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 719,038,980.86 | 00.00 | -21,395,178.19 | 697,643,802.67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **719,038,980.86** | **00.00** | **-21,395,178.19** | 697,643,802.67 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -22,612,800.34 | -22,612,800.34 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **779,038,980.86** | **477,701,035.36** | **-64,084,084.69** | 1,192,655,931.53 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **779,038,980.86** | **477,701,035.36** | **-64,084,084.69** | 1,192,655,931.53 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **779,038,980.86** | **477,701,035.36** | **-64,084,084.69** | 1,192,655,931.53 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -4,760,540.28 | -4,760,540.28 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **779,038,980.86** | **477,701,035.36** | **-68,844,624.97** | 1,187,895,391.25 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 431,279,600.00 | 413,830,477.50 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 431,279,600.00 | 413,830,477.50 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 431,129,000.00 | 413,680,477.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 324,674,500.00 | 318,197,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 265,845,700.00 | 262,253,110.60 |
| 210102 | Нэмэгдэл | 31,568,400.00 | 28,498,281.40 |
| 210104 | Урамшуулал | 27,260,400.00 | 27,446,308.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 40,584,400.00 | 42,751,639.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,597,400.00 | 29,845,639.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,246,700.00 | 3,199,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,597,500.00 | 2,559,840.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 649,400.00 | 639,960.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,493,400.00 | 6,506,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,884,200.00 | 17,830,165.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,563,300.00 | 3,050,192.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,208,100.00 | 9,670,744.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,112,800.00 | 5,109,229.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,281,700.00 | 3,216,170.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 387,500.00 | 387,520.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 438,800.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 251,000.00 | 225,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,800.00 | 200,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 250,600.00 | 150,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,753,000.00 | 1,752,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,493,300.00 | 27,473,903.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 796,500.00 | 795,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 38,291,200.00 | 25,273,833.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,405,600.00 | 1,405,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,800,000.00 | 1,800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 99,000.00 | 99,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 99,000.00 | 99,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 957,500.00 | 957,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр ху | 717,500.00 | 717,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1354400.00 | 1354400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,000.00 | 250,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,104,400.00 | 1,104,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 150600.00 | 150000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 150,600.00 | 150,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 150,600.00 | 150,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 431,279,600.00 | 427,774,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 411,595,400.00 | 408,090,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 411,595,400.00 | 408,090,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 411,595,400.00 | 408,090,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 19,684,200.00 | 19,684,200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 19,684,200.00 | 19,684,200.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 30.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00.00 | 00.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **297,000.00** | **140,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **297,000.00** | **140,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 297,000.00 | 140,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 297,000.00 | 140,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 297,000.00 | 140,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 297,000.00 | 140000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 297,000.00 | 140,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 297,000.00 | 140,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг С.Үднаран танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 19–ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дэлгэрмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэг 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Хүүхэд бүрийн хувийн онцлогт тохирсон, систем сургалтын орчинг бүрдүүлж тэдний тал бүрийн хөгжлийг хангах арга зүй технологийг боловсруулан, тасралтгүй сургах үйлийг дэмжихэд оршино"

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт, дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 472806.7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 9,456.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос -4,103.6 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар өссөн байна. өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | 656.9 | 656.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 49,745.1 | 41,041.5 | -8,703.6 |
| Үндсэн хөрөнгө | 1,142,910.8 | 1,146,853.9 | 3,943.1 |
| **Нийт хөрөнгө** | **1,192,655.9** | **1,188,552.3** | **-4,103.6** |
| Өр төлбөр | - | 656.9 | 656.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,192,655.9 | 1,187,895.4 | -4,760.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,192,655.9** | **1,188,552.3** | **-4,103.6** |

Авлага, өглөгийн дансны үлдэгдэл 656.9 мянган төгрөг болсон нь хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөгөөр бүртгээгүй байсан тул санхүүгийн тайлангаар авлага, өглөг үүсгүүлсэн**.**

Бараа материалын дансны үлдэгдэл 41,041.5мянган төгрөг болж 8,703.6 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалаас үндсэн хөрөнгийн данс руу хөрөнгө шилжүүлснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,146,853.9мянган төгрөг болж 3,943.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгө элэгдлийн зардлаас өндөр байгаа нь нөлөөлсөн байна.

Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 99,736.3 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 84,393.9 мянган төгрөгөөр буюу 21.7 хувиар өссөн байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 631,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 631,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 199,720.4 мянган төгрөгөөр бууруулж 431,279.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 431,279.6 мянган төгрөгийн төсөв батлагдсаныг улсын төсвөөс 411,595.4 мянган төгрөг, орон нутгаас 19,684.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 427,774.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт урсгал үйл ажиллагаанд 413,830.5 мянган төгрөгийг зарцуулж 13,944.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого

Улсын /орон нутгийн/ төсөвт орлого төвлөрүүлдэггүй байна.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд буюу цахим тендерээс бий болсон 140.0 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.
Үүнээс бичиг хэргийн зардалд 140.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, 5 дугаар сарын 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 71,400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлагыг биелүүлсэн байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

/мян.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | Биелэлт | Зөрүү |
|---|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Албан шаардлага | 2 | 71,400.0 | 2 | 71,400.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 2 | 71,400.0 | 2 | 71,400.0 | 0.0 | 0.0 | 100.0 |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,313.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 656.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 656.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

**Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос 656,915.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцон нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулав.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 656.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрсэнд 1 албан шаардлага хүргүүллээ.

Үүнд: Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос 656,915.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18.1.1 дэх "хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ..."гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад 2018 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар тавигдсан төлбөрийн актын үлдэгдэл 4.5 сая төгрөгийг барагдуулаагүйг аймгийн Прокурорын байгууллагад шилжүүлсэн байна. Иймд санхүүгийн тайлангийн дараагийн анхаарал татахуйц асуудалд оруулах нь зүйтэй гэж үзэв.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:* Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад 5 дугаар сарын 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

*1.2.* *Эрсдэл:* Хууль журам хэрэгжихгүй байх, төсвийн ил тод байдал алдагдах.

*1.3.* *Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: **2020**

Аудитын нэр: ***Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит***

Аудитын код: ДОА-2021/72/СТА-ТШ3

А

Шалгагдсан байгууллагын нэр: ***Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэг***

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Цалингийн зардалд дахин тооцоолол хийж шалгах явцад Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 656,915.0 төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутган тооцсон байна. | 656.9 | Албан шаардлага | Эрхлэгч, Нягтлан бодогч | С.Үднаран Г.Солонго |
| 2 | Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журнал болон анхан шатны санхүүгийн мэдээ тайлангуудтай тулгахад 5 дугаар сарын 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | 0.0 | Зөвлөмж | Эрхлэгч, Нягтлан бодогч | С.Үднаран Г.Солонго |
| 3 | Хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтны цалингийн орлогоос нийт 656,915.0 төгрөгийн ХХОАТ-ыг суутган авч шилжүүлсэн бөгөөд тооцон нийлсэн актаар баталгаажуулан авлага, өглөг үүсгээгүй байсныг залруулав. | 656.9 | Алдааг залруулсан | Эрхлэгч, Нягтлан бодогч | С.Үднаран Г.Солонго |
| **ДҮН** | | 1,313.8 | | | |